



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР**

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020. 08. 13 № 511

таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г  
ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЦАГААН-ОВОО  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА  
Т.БАЯРМАГНАЙ ТАНАА

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт<sup>1</sup>

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Цагаан-Овоо сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагаан-Овоо сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардгаха зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Цагаан-Овоо сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан узэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

"Цагаан-Овоо сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Цагаан-Овоо сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /.... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт . . . . . хуудастай.


ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020591

Цагаан-Овоо сумын Монгол Ардын намын хорооны  
2020 оны 07 сарын 13, эдрийн 10 дугаар  
тогтоолын 1 хавсралт



**ДОРНОД АЙМГИЙН ЦАГААН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНООС 2020 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



ЦАГААН-ОВОО СУМ

## ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Их хурлаар баталсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр холбогдох хууль тогтоомж, сум орны хөгжлийн хэтийн төлөвийн талаарх иргэдийн санал бодол, мэргэжилтнүүдийн судалгаанд үндэслэн мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Цагаан-Овоо сумын Монгол Ардын намын хороо нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд дараах мөрийн хөтөлбөрийг дэвшүүлэн оролцож байна. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд Монгол Ардын намаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөтөлбөрийн гол үндсэн баримт бичиг мөн.

Мөрийн хөтөлбөрийн эрхэм зорилго нь **ИРГЭНЭЭ** дээдэлсэн нутгийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, сумын хөгжлийн төлөө **ТӨРИЙН АЛБАНЫ ЧАДАВХИ**, хариуцлага, хяналтын тогтолцоог сайжруулж, бэхжүүлэхэд оршино.

- Сумын хөгжил, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах бодлогын хүрээнд - 18
- Нийгмийн бодлогын хүрээнд - 14
- Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд - 7

Гэсэн үндсэн 3 бүлэг 40 зорилттой байна.




**НЭГ: Сумын хөгжил, төрийн үйлчилгээний чанар хүртээмж сайжруулах бодлогын хүрээнд**

- 1.1 Сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулж , хэрэгжүүлнэ.
- 1.2 Сумын доторх төв замыг хатуу хучилттай болгож, сайжруулан тэмдэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 1.3 Сумын Нутгийн удирдлагын ордны их засварыг бүрэн хийнэ.
- 1.4 Сумын төвийг бүрэн камержуулна.
- 1.5 Сумын төвийн гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулан нэмэгдүүлнэ.
- 1.6 Орлого багатай өрхийг хямд өргөөр орон сууцжуулах ажлыг эрчимжүүлнэ.
- 1.7 Гүн-Цэнгэлэг нуурын амралтын газрыг сэргээн засварлаж, шинээр тохижуулан төвийн эрчим хүчинд холбоно.
- 1.8 /дотуур байр 2-ыг сэргээн засварлаж/ тус суманд шинээр ирж ажиллаж буй төрийн албан хаагчдыг байраар хангана.
- 1.9 Багийн төвүүдийг төвлөрсөн болон нар салхины эрчим хүчиний эх үүсвэртэй болгоно.
- 1.10 Багийн Засаг дарга нарыг унаажуулна.
- 1.11 Төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулаж, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.
- 1.12 Сумын иргэдийн интернет, үүрэн холбоо, телевиз, радио үйлчилгээний хурд, багтаамжийг нэмэгдүүлнэ.
- 1.13 Дорнод аймгийн Цагаан Овоо сум ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын Агын тойргийн Дульдургын районы Узон хамтрайтай уламжлалт харилцаагаа сэргээн хөгжүүлнэ.
- 1.14 БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Евэнх хошууны Мөнгөнчулуу сумтай соёл, хөдөө аж ахуй газар тариалангийн салбарт хамтран туршлага солилцно.
- 1.15 БНУнгар улсын тосгонтой хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллах, Хөдөө аж ахуйн чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, залуу малчид, хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийн гадаадын улс оронд туршлага судлах аялал хийхийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.16 Архи, согтууруулах ундааны зохистой хэрэглээг сумандаа хэвшүүлэх бодлогын арга хэмжээ авч, “Архигүй амьдрал” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.17 Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, цагдаагийн ажиллах орчин тоног төхөөрөмжийг сайжруулна.
- 1.18 “Степ Голд” ХК-тай жил бүр нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг иргэдэд ил тод нээлттэй мэдээлж ажиллана.

**ХОЁР: Нийгмиийн бодлогын хүрээнд**


- 2.1 Орон нутаг судлах танхимыг их засварт оруулж байнгын ажилалгаатай болгоно
- 2.2 320 хүүхдийн бага сургуулийн барилга шинээр барина
- 2.3 ЕБС болон дотуур байрны гадна орчинд тохижилт хийж хашаа хайсыг шинэчлэн ногоон байгууламжыг нэмэгдүүлнэ
- 2.4 Хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн барилга барина



- 2.5 Цэцэрлэгийн гадна орчинд тоглоомын талбай, биеийн тамирын талбайг байгуулна.
- 2.6 Сургууль, цэцэрлэгийн удирдлага, багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх туршлага гадаад дотоодод туршлага судлах, мэргэжлийн зэргийг ахиулах ахиулах зэрэг ажлыг зохион байгуулан дэмжиж ажиллана
- 2.7 Суманд "Соёл урлагийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ
- 2.8. Цэцэрлэгийн урлаг зааланд засвар, тохижилтыг хийж цэцэрлэгийн хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх боломжыг нэмэгдүүлнэ
- 2.9 Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд ёс заншил өв уламжлалаараа бахархах төлөвшүүлэх зорилгоор "Буриадамнай" төсөл хэрэгжүүлнэ
- 2.10 Эмнэлэгт Шүдний кабинет ажиллах боломж бүрдүүлнэ
- 2.11 Эмнэлэгийн гадна орчинд ногоон байгууламж бүхий хөдөлгөөн засал чийрэгжилтийн тоног төхөөрөмж бүхий орчин бүрдүүлнэ
- 2.12 Сумын нийт хүн амд үзүүлэх нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусlamж үйлчилгээг сайжруулна
- 2.13 Алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах боломжийг хангаж явуулын эрүүл мэндийн баг тогтмол ажиллуулна.
- 2.14 Ахмад настан нярай хүүхдийн зуны сувилалыг тогтмолжуулж хамрах хүрээ чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ

#### **ГУРАВ: Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд :**

- 3.1 Мал сүргийн чанар, үүлдэр угсааг сайжруулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана
- 3.2 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг бодлогын хүрээнд дэмжиж ажиллана
- 3.3 Сумын мал сүрэгт гоц халдварт, халдварт шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлнэ.
- 3.4 Суманд сүү боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан дэмжиж ажиллана
- 3.5 Газрын нөөц, боломжид тулгуурлан сумын атар болон атаршсан талбайг сэргээн тариалалт хийж, төмс, хүнсний ногоо, тэжээл, үр тарианы үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 3.6 Хүн амыг төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах зорилт тавьж ажиллана.
- 3.7 Сумын төсөвт байгууллага, иргэдийг хүлэмжтэй болгох ажлыг дэмжинэ.



ЦАГААН-ОВОО СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО